

# Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого

## Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

### 2020 оны жилийн эцэс

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	
4.1. Шинжлэх ухаан, технологийн салбарын бүтэц, зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгох							
1	4.1.1. холбогдох хууль тогтоомж бусад эрх зүйн баримт бичиг, үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг улс орны нийгэм, эдийн засаг болон шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түвшин, олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх	2017 - 2020			Инновацийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-аар 2019 онд батлуулан мөрдөж байна. Энэхүү хууль батлагдсанаар инновацийн үйл ажиллагааг дэмжих олон талт эх үүсвэрийг бий болгох, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн дэргэд зөвлөх компани байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, гарааны компани, ЭШБ, ИДС бүтээгдэж буй шинэ мэдлэг, инновацийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, эдийн засагжуулах боломжийг нээж өгсөн. Засгийн газрын 2020 оны 33 дугаар тогтоолоор “Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр”, 95 дугаар тогтоолоор “Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл”, Засгийн газрын 2019 оны 162 дугаар тогтоолоор “Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”, 392 дугаар тушаалаар “Инновацийн төсөл бүртгэх журам”, -ийг тус тус батлуулаад байна. Дээр дурьдсан эрх зүйн баримт бичгээс гадна “Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийг УИХ-ын чуулганы хуралдаанд хэлэлцүүлж батлуулахаар ажиллаж байна. Цаашид “Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл”, “Судалгааны их сургуулийн тухай хуулийн төсөл”, “Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тодотгол хийх журмын төсөл”-ийг тус тус батлуулахаар холбогдох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Эдгээр хууль тогтоомжийн төсөлд судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулж буй төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, санхүүжилтийн		100%

				зарчмыг шинэчлэх, улсын төсвөөс гадна гадаад дотоодын тусгай зорилтот сангууд зэрэг санхүүжилтийн олон эх үүсвэрийг бий болгох замаар оновчтой механизмыг бүрдүүлэн хөгжүүлэх, тэдгээрт шаардагдах хүний нөөц, ялангуяа судлаачдын чадавхийг бэхжүүлэхэд эерэг үр дүнг авчрах зохицуулалтыг тусгасан болно.	
2	4.1.2. салбарын бүтэц, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох	2017 - 2020		Шинжлэх ухаан, технологийн сангийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулах санал, шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг БСШУС-ын сайдын 2020 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/107 дугаар тушаалаар байгуулж “Шинжлэх ухаан, технологийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан. Тогтоолын төслийн хүрээнд Засгийн газрын 2019 оны 50 дугаар тогтоолоор баталсан “Шинжлэх ухаан, технологийн сангийн дүрэм”-д нэмэлт, өөрчлөлт оруулах дүрмийн төсөл, “Шинжлэх ухаан, технологийн төсөлд тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам”-ын төслийг боловсруулсан. Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Шинжлэх ухаан, технологи, инновацийн үндэсний газар”-ыг байгуулах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж яамдаас санал авсан. БШУ-ны яамны харьяа зарим байгууллагуудын батлагдсан төсөв, орон тоо, эргэлтийн хөрөнгөөс шилжүүлэн зохицуулалт хийн шинэ агентлагийг байгуулах боломжтой. Шинжлэх ухаан, технологи, инновацийн Үндэсний хэрэгжүүлэгч агентлаг байгуулагдсанаар шинжлэх ухаан болон технологийг тус тусад нь болон харилцан холбоотой дэмжих боломжийг бүрдүүлж, шинжлэх ухаан, технологийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн, бүртгэл тооцоо, төлөвлөлт, зарцуулалтын арга хэлбэр, санхүүжилтийн механизм, салбарын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын нэгдсэн удирдлага сайжран салбарын бүтээмж нэмэгдэх болно гэж үзсэн. Өөр нэг хувилбар бол Шинжлэх ухаан технологийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, ажлын албыг зохион байгуулж Шинжлэх ухаан технологийн хуульд заасан чиг үүргийнх нь дагуу ажиллуулах зохион байгуулалтыг хийхээр ажиллаж байна.	70%
3	4.1.3. шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагаанд	2017 - 2020		Инновацийн тухай хуулийн 16 зүйлд заасны дагуу технологи дамжуулах төв, эсхүл хамтын оффисд гишүүнчлэлээр бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг төрөөс татварын бодлогоор дэмжих журмын төслийг	70%

<p>хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн эдийн засгийн таатай орчныг бүрдүүлж, төр, олон нийт, хувийн хэвшлийн үр ашигтай түншлэлийг дэмжих</p>			<p>боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Мөн гарааны компаниуд хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгох боломжийг бүрдүүлэхтэй холбоотой эрхзүйн орчныг сайжруулах, гарааны компанийн олон нийтэд хувьцаа санал болгох журмыг боловсруулах, олон нийтэд санал болгох нийт хувьцааны болон нэг хөрөнгө оруулагчийн худалдан авах хувьцааны үнийн дүнгийн дээд хязгаарыг тогтоох чиглэлээр судалгааны ажлууд хийгдэж байна. Инновацийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтыг үндэслэн Засгийн газрын 2020 оны 33 дугаар тогтоолоор “Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийг баталж, “Үндэсний хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах”-ыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдад даалгасан байдаг. Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх асуудал нь нийгэм, эдийн засгийн бүхий л салбарын оролцоотойгоор хэрэгжих өргөн хүрээтэй асуудал тул арга хэмжээний төлөвлөгөөний төслийг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд сайд нарт танилцуулж, Засгийн газрын 59 дүгээр хуралдааны тэмдэглэл гаргасан. Төлөвлөгөөний төсөл батлагдан, хэрэгжсэнээр инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх, инноваци шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийг бий болгоход хувийн хэвшлийн оролцоог төрөөс хөхүүлэн дэмжих, цаашлаад эдийн засагт инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эзлэх байр суурийг бэхжүүлж, үндэсний инновацийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэхэд томоохон ахиц дэвшил гарна гэж үзэж байна.</p>	
<p>4.1.4. салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг олон улсын жишигт нийцүүлж, статистикийн мэдээллийн тогтолцоог сайжруулах</p>	<p>2017 - 2020</p>		<p>БШУ-ны яамны захиалгаар SICA судалгааны байгууллага “Шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн үзүүлэлтүүдийг тооцоолох арга зүй, мэдээлэл цуглуулах маягт, зааврыг олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох нь” сэдэвт захиалгат төслийг хэрэгжүүлсэн. Төслөөс гарсан санал, зөвлөмжийг тусган Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа болон судалгаа, хөгжүүлэлтийн ажил, түүнтэй холбоотой статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлалыг олон улсад мөрдөж буй Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Фраскатиин гарын авлагын дагуу боловсруулсан. БШУ-ны сайдын 2020 оны А/59 тоот тушаалаар “ШУТ-ийн салбарын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, маягтыг шинэчлэн боловсруулж батлуулах” чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан аргачлал, маягтын төслийг шинэчлэн боловсруулж Үндэсний статистикийн газарт хүргүүлэн Арга зүйн байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Үндэсний статистикийн газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/69, А/71 дүгээр</p>	<p>90%</p>

				тушаалаар ШУТ-ийн салбарын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, маягт, нөхөх зааврыг тус тус баталсан. Шинэчлэн батлагдсан статистикийн маягтуудад судалгааны хамрах хүрээг өргөжүүлж зөвхөн эрдэм шинжилгээний байгууллага бус төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, мэргэжлийн байгууллагуудыг хамруулахаар болсон.	
5	4.1.5. шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцогчдын хариуцлагыг өндөржүүлж, гүйцэтгэлийн хяналтыг боловсронгуй болгох	2017 - 2020		ЮНЕСКО-ийн 39 дүгээр Ерөнхий бага хурлын чуулганаар батлагдсан “Шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний ажилтнуудад зориулсан зөвлөмж”-ийг монгол хэлнээ орчуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Олон улсын нэр хүндтэй байгууллага болох ЮНЕСКО-гийн өмнө хүлээсэн гишүүний үүргээ биелүүлэх, төр засгаас батлан хэрэгжүүлж буй бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх замаар салбарын цаашдын хөгжлийг хангахад чухал ач холбогдолтой юм. Боловсрол, соёл, шинжлэх ухааны, спортын сайдын 2018 оны А/754 дугаар тушаалаар яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүн батлагдсан. УИХ-д өргөн барьсан Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дүрмийг шинэчлэн боловсруулах ажлыг 2021 оны төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.	100%
6	4.1.6. төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагад үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрт оролцох, туршилт-үйлдвэрлэл эрхлэх боломжийг бий болгох	2017 - 2020		Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байгаа Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд эрдэм шинжилгээний байгууллага, ажилтны нийтлэг эрх, үүрэгт өөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэлээр аж ахуйн гэрээт ажил гүйцэтгэх болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх асуудлыг нэмж тусгасан.	70%
7	4.1.7. бүс болон	2017 -		Ховд их сургуулийг түшиглэн Баруун бүсийн судалгааны төв байгуулах асуудлыг	30%

	орон нутгийн онцлогийг харгалзан эрдэм шинжилгээний төв, хүрээлэн байгуулахыг дэмжих	2020			судалж байна.	
8	4.1.8. шинжлэх ухааны мэдлэг, инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	2017 - 2020			“Шинжлэх ухааны ажилтны өдөр-2020”-ийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн А/132 тушаалаар батлуулан, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулж ажилласан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн А/68 дугаар “Төлөвлөгөө батлах тухай” тушаалаар Монгол Улсын боловсрол, шинжлэх ухааны салбарын 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг нэгдсэн удирдлага зохицуулалтаар ханган ажиллаж байна.	70%
9	4.1.9. салбарын үйл ажиллагаанд мэргэжлийн нийгэмлэг, холбоодын оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх	2017 - 2020			2015 онд батлагдсан Хууль, тогтоомжийн тухай хуулийн 9.5-т Хууль тогтоомжийн төсөл боловсруулах явцад холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллага, шинжээч, эрдэмтэн, иргэн, хуулийн этгээдээс санал авч, төсөл боловсруулахад харгалзан үзэхээр туссан. 2015 онд батлагдсан Захиргааны ерөнхий хуулийн 62.3.2-т захиргааны хэм хэмжээний актын төслийн хэлэлцүүлгийг эрдэмтэн, судлаач, шинжээч зэрэг мэргэшсэн хүрээнд зохион байгуулахаар зохицуулсан. Хуульд заасны дагуу шинээр боловсруулагдаж буй салбарын эрх зүйн баримт бичгийн төслийн хэлэлцүүлгийг хийж салбарын болон мэргэжлийн байгууллагуудын саналыг тусган ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор 2019 онд зохион байгуулсан Монголын шинжлэх ухааны ажилтны анхдугаар их хуралд шинжлэх ухааны үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын төлөөлөл оролцож салбарын ололт амжилт, тулгамдаж буй асуудлуудыг цэгнэн ярилцаж зөвлөмж гаргасан. Их хурлаас гарсан шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэхээр “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 379 дүгээр тогтоолыг батлан хэрэгжүүлж байна.	90%

4.2. Судалгаа боловсруулалтын ажлыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх						
10	4.2.1. шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийг олон улсын чиг хандлага, улс орны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан тодорхойлж хөгжүүлэх	2017 - 2020			Шинэчлэн батлагдсан статистикийн захиргааны маягтын дагуу холбогдох мэдээллийг Статистикийн тухай хуулийн дагуу эрдэм шинжилгээний байгуулага, их дээд сургуулиудаас openscience.mn нэгдсэн платформоор дамжуулан 2021 оны 1 дүгээр улиралд багтаан авч нэгтгэн боловсруулж байна.	50%
11	4.2.2. судалгаа боловсруулалтын ажлыг шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, улсын эдийн засаг, нийгмийн хэрэгцээ, шаардлагатай уялдуулан хөгжүүлэх	2017 - 2020			Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 368 дугаар тогтоолоор 2015-2021 онд Монгол улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх нийт 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх нийт 18 цөм технологийн жагсаалтыг батлан хэрэгжүүлж байна. Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын тэргүүлэх чиглэлийн хүрээнд явуулах судалгаа шинжилгээ, туршилтын ажлыг дэмжих, өндөр технологит салбаруудыг хөгжүүлэхэд чиглэсэн судалгаа боловсруулалтын ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах, хөрөнгө, хүчийг төвлөрүүлэн үр ашигтай зарцуулах зорилгоор тэргүүлэх чиглэл, цөм технологийн 20 төсөлд нийт 8,030,020.0 мян.төгрөгийг Улсын төсвөөс санхүүжүүлэн хэрэгжүүлсэн байна. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тодотгол хийх журамд нэмэлт өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан ажиллаж байна.	100%
12	4.2.3. үндэсний аж үйлдвэрийн технологийг хөгжүүлэх судалгаа	2017 - 2020			Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2014 оны 301 дугаар тогтоолоор батлагдсан “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-ын дагуу жил бүр шинжлэх ухаан, технологийн төслийг сонгон шалгаруулж, хэрэгжүүлдэг. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/146 дугаар тушаалаар 2020 оноос шинээр эхлэх 31	90%

	боловсруулалтын ажлыг дэмжих			шинжлэх ухаан, технологийн төсөлд нийт 2,546,000.0 мян.төг санхүүжилт батлагдсан. Мөн “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-ын дагуу 2020 онд үргэлжлэн хэрэгжиж буй 54 шинжлэх ухаан, технологийн төсөлд 2020 онд нийт 1,815,695.5 төгрөгийн санхүүжилт олгох ёстой. Гэвч Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар эрдэм шинжилгээний ажлын санхүүжилт буурч батлагдсантай холбоотойгоор 2020 онд үргэлжлэн хэрэгжих шинжлэх ухаан, технологийн төслийн санхүүжилт олгогдоогүй. “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-ын дагуу шинжлэх ухаан, технологийн төслийн хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд хяналт тавих, үнэлгээ өгч дүгнэлт гаргах зорилгоор төслүүдийн гүйцэтгэл, тайлангийн онлайн хэлэлцүүлгийг 2021 оны 02 дугаар сарын 5-ны өдөр зохион байгуулга . Корона вируст халдвар /Covid-19/-тай холбоотой 5 судалгааны ажлыг БШУ-ны сайдын 2020 оны А/282, А/58, А/168 дугаар тушаалаар тус тус батлан 2020-2021 онд хэрэгжүүлж байна.	
13	4.2.4. судалгаа боловсруулалтын ажил гүйцэтгэхэд шаардлагатай лабораторийн болон туршилт-үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, мал, амьтан, туршилтын талбай, ургамал, бусад материалыг татвар, төлбөрөөс чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгуулах замаар судлан	2017 - 2020		Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй ХААИС-ийн харьяа Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн тариалангийн газрыг “Газрын тухай” хуулийн дагуу улсын тусгай хэрэгцээт газарт авлаа. Жил бүр инновацийн бараа бүтээгдэхүүн үйлчилгээний зориулалттай гарааны компанийн гадаадаас оруулж ирж буй тоног төхөөрөмжийн жагсаалтыг Засгийн газраар батлуулж гааль, татварын хөнгөлөлт үзүүлж байна.	100%

	шийдвэрлэх					
14	4.2.5. судалгаа боловсруулалтын ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийн харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2017 - 2020			Шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор БШУ-ны яамнаас жил бүр Инновацийн төсөлд грант олгох, технологийн туршилт зүгшрүүлэлтийн төслүүдийг сонгон шалгаруулж хэрэгжүүлдэг. 2020 оны байдлаар өмнөх жилүүдэд батлагдсан инновацийн 5 грант төсөл, технологийн туршилт зүгшрүүлэлтийн 35 төсөл үргэлжлэн хэрэгжиж байна. 2020 онд салбарын хэмжээнд эрдэм шинжилгээний зардал танагдсантай холбоотойгоор судалгаа боловсруулалтын ажлуудын үр дүн тасалдах, хойшлоход хүрээд байна. Мөн санхүүжилтийн хүндрэлтэй байдлаас шалтгаалах 2020 оноос эхлэн хэрэгжүүлэхээр сонгон шалгаруулсан инновацийн грант төсөл, Технологийн туршилт зүгшрүүлэлтийн төслүүд батлагдаагүй.	70%
15	4.2.6. судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэхэд санхүүжилт, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх	2017 - 2020			Засгийн газрын 2018 оны 282 дугаар тогтоолоор баталсан Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр АХБ-аас бодлогын зээлээр дэмжихээр болсон. Азийн хөгжлийн банкны 30 сая ам.долларын хөнгөлөлтэй зээлээр 2021-2024 онуудад хэрэгжих “Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх” төслийн хүрээнд шинжлэх ухааны байгууллагуудын бүтээл, судалгааны үр дүнг их, дээд сургуулийн сургалтад ашигладаг механизмыг бүрдүүлж, сургалт, судалгаа, инновацийн төвүүдийг их, дээд сургуулиудад байгуулахаар ажиллаж байна.	70%
16	4.2.7. шинжлэх ухаан, технологийг инноваци, бүсчилсэн хөгжил, аж үйлдвэрийн бодлоготой нягт уялдуулан хөгжүүлэх	2017 - 2020			“Монгол Улсад инкубаторын үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон мэдээллийн серверийн бүтээн байгуулалт” болон “Технологи дамжуулах төвийн платформыг байгуулах” төслүүдийг БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн яамтай хамтран хэрэгжүүлж байна. Улсын төсвийн санхүүжилтээр “Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор”-ын газрын асуудлыг шийдвэрлүүлж, зураг төслийг боловсруулан бүтээн байгуулалтын ажлыг 2020 оны 10 дугаар сард эхлүүлсэн.	70%
4.3. Шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгож, дотоодын нийт бүтээгдэхүүнд шинжлэх ухаан, технологийн салбарын төсвийн санхүүжилтийн эзлэх хувийг 2016-2020 онд 2 хувь, 2021-2025 онд 2,5 хувь хүргэх						



17	4.3.1. салбарын төсвийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгох	2017 - 2020		2020 оны байдлаар, шинжлэх ухаан, технологийн 315 төсөл үргэлжлэн хэрэгжиж, 236 төслийг шинээр эхлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд нийтдээ 526 төсөл хэрэгжинэ. Үүнээс, суурь судалгааны төсөл 198, захиалгат 95, цөм технологийн 4, инновацийн 5, туршилт зүгшрүүлэлтийн 36, гадаадтай хамтарсан 119, грант 69 байна. Эндээс үзэхэд, судалгааны ажлын 35.6 хувийг суурь судалгаа, 17.5 хувийг хэрэглээний судалгаа, 12.8 хувийг технологийн судалгаа, 21.6 хувийг гадаадтай хамтарсан, 12.5 хувийг грант төсөл эзлэж байна. Нэг төсөлд оногдох дундаж санхүүжилт 19.8 сая төгрөг байна. Эрдэм шинжилгээний байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн ажлыг зөвхөн төсөл хэлбэрээр явуулах нь байгууллагууд өөрийн судалгааны үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх тогтвортой үйл ажиллагаа алдагдах, судалгааны ажлын онол арга зүйн хүрсэн түвшин буурах, судалгаа боловсруулалтын ажлын чанар, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг сулруулахад хүргэж байна. Иймд судалгаа хөгжүүлэлтийн ажлыг төслийн сонгон шалгаруулалтаар, эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбогдсон судалгааг суурь санхүүжилт олгох замаар санхүүжүүлдэг хосолсон тогтолцоог бүрдүүлэх бодлогыг баримталж, Засгийн газарт өргөн мэдүүлээд байгаа Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан.	50%																							
18	4.3.2. дотоодын нийт бүтээгдэхүүнд шинжлэх ухаан, технологийн салбарын төсвийн санхүүжилтийн эзлэх хувийг үе шаттайгаар тогтвортой нэмэгдүүлэх	2017 - 2020	<p>2020 оны улсын төсөвт шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт хуваарилсан төсвийн зардал 51.2 тэрбум төгрөг байгаа нь ДНБ-ий 0.10 хувь эзэлж байна. Энэ нь "Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого", "Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого"-Д заасан зорилтот хэмжээнээс даруй 3 дахин бага байна. Хүснэгт. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын төсвийн зардал /сая. төг/ Үзүүлэлт</p> <table border="1"> <thead> <tr> <th></th> <th>2016</th> <th>2017</th> <th>2018</th> <th>2019</th> <th>2020</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Шинжлэх ухааны салбарын нийт зардал</td> <td>32,985.0</td> <td>32,846.4</td> <td>34,623.3</td> <td>37,269.0</td> <td>51,152.8</td> </tr> <tr> <td>Урсгал зардал</td> <td>29,864.3</td> <td>31,570.4</td> <td>34,623.3</td> <td>37,269.0</td> <td>48,152.8</td> </tr> <tr> <td>ДНБ-д эзлэх хувь</td> <td>0.14%</td> <td>0.12%</td> <td>0.12%</td> <td>0.11%</td> <td>0.10%</td> </tr> </tbody> </table> <p>Нийт зардлын дийлэнхи хувь нь салбарын ажиллагчдын цалин хөлсний нэмэгдэл, төрийн албан хаагчдад тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжтэй холбоотой зардал эзэлж байна. Харин эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын санхүүжилт сүүлийн 3 жилд нэг ч төгрөгөөр нэмэгдээгүй бөгөөд 12.0 тэрбум төгрөг хэвээр байна.</p>		2016	2017	2018	2019	2020	Шинжлэх ухааны салбарын нийт зардал	32,985.0	32,846.4	34,623.3	37,269.0	51,152.8	Урсгал зардал	29,864.3	31,570.4	34,623.3	37,269.0	48,152.8	ДНБ-д эзлэх хувь	0.14%	0.12%	0.12%	0.11%	0.10%	70%
	2016	2017	2018	2019	2020																							
Шинжлэх ухааны салбарын нийт зардал	32,985.0	32,846.4	34,623.3	37,269.0	51,152.8																							
Урсгал зардал	29,864.3	31,570.4	34,623.3	37,269.0	48,152.8																							
ДНБ-д эзлэх хувь	0.14%	0.12%	0.12%	0.11%	0.10%																							
19	4.3.3. шинжлэх ухаан,	2017 - 2020	Инновацийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх дэд бүтэц, орчныг бүрдүүлэх, импортыг орлох, экспортод чиглэсэн өндөр технологи, инновацийн	50%																								

	технологийн салбарт санхүүжилт, хөрөнгө оруулалтын олон талт эх үүсвэрийг бий болгох			бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шаардагдах санхүүгийн олон талт эх үүсвэрээр хангах зорилгоор ШУПаркийн захиргаа байгуулан ажиллаж байна. Засгийн газрын 2020 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр”-т инновацийн тэргүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд үйлдвэрлэл, гарааны бизнест Хөгжлийн банк, Жижиг дунд, үйлдвэрийг хөгжүүлэх сан болон Засгийн газрын бусад тусгай сангаас нэн тэргүүнд санхүүжилт хийх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, төрийн бодлогоор дэмжихээр тусгасан. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 16.1 дэх хэсэг, Засгийн газрын 2014 оны 301 дүгээр тогтоолоор “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-ыг батлан мөрдүүлж, Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх харилцааг зохицуулж байна. Эрдэм шинжилгээний байгууллагын судалгаа хөгжүүлэлтийн ажлыг зөвхөн төсөл хэлбэрээр явуулах нь байгууллагууд өөрийн судалгааны үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх тогтвортой үйл ажиллагаа алдагдах, судалгааны ажлын онол арга зүйн хүрсэн түвшин буурах, судалгаа боловсруулалтын ажлын чанар, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг сулруулахад хүргэж байна Иймд судалгаа хөгжүүлэлтийн ажлыг төслийн сонгон шалгаруулалтаар, эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбогдсон судалгааг суурь санхүүжилт олгох замаар санхүүжүүлдэг хосолсон тогтолцоог бүрдүүлэх бодлогыг баримталж, Засгийн газарт өргөн мэдүүлээд байгаа Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан.	
20	4.3.4. эрдэм шинжилгээний байгууллагууд үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд нэмэлт орлого олох, түүнийг захиран зарцуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2017 - 2020		Эрдэм шинжилгээний байгууллагууд үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд нэмэлт орлого олох, түүнийг захиран зарцуулах эрх олгох, төсвийн бус данс нээх чиглэлд Сангийн яаманд хүсэлтээ хүргүүлсэн. “Шинжлэх ухаан, инновацийн салбарын байгууллагуудын хамтын ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв” чөлөөт хэлэлцүүлгийг 2020 оны 12-р сарын 11-ний өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт их, дээд сургууль, эрдэм шинжилгээний багууллагуудын нийт 50 гаруй төлөөлөл оролцож, салбарын бодлого, эрх зүй, зохицуулалт хөрөнгө оруулалт, дэд бүтэц гэх мэт туламдсан асуудлын талаар санал бодлоо чөлөөтэй солилцож, хамтын ажиллагааны бодит саналуудыг хэлэлцсэн.	50%
21	4.3.5. төрийн	2017 -		Инновацийн тухай хуулийн 16 зүйлд заасны дагуу технологи дамжуулах төв,	50%

	өмчит эрдэм шинжилгээний байгууллагуудад хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, захиалгат, хамтарсан судалгаа боловсруулалтын ажил гүйцэтгэх эдийн засгийн хөшүүргийг бий болгож, эрх зүйн орчныг бүрдүүлэх	2020		эсхүл хамтын оффисд гишүүнчлэлээр бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг төрөөс татварын бодлогоор дэмжих журмын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Мөн гарааны компаниуд хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгох боломжийг бүрдүүлэхтэй холбоотой эрхзүйн орчныг сайжруулах, гарааны компанийн олон нийтэд хувьцаа санал болгох журмыг боловсруулах, олон нийтэд санал болгох нийт хувьцааны болон нэг хөрөнгө оруулагчийн худалдан авах хувьцааны үнийн дүнгийн дээд хязгаарыг тогтоох чиглэлээр судалгааны ажлууд хийгдэж байна. Засгийн газрын 2020 оны 33 дугаар тогтоолоор “Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийг баталж, “Үндэсний хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах”-ыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдад даалгасан. Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх асуудал нь нийгэм, эдийн засгийн бүхий л салбарын оролцоотойгоор хэрэгжих өргөн хүрээтэй асуудал тул арга хэмжээний төлөвлөгөөний төслийг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд сайд нарт танилцуулж, Засгийн газрын 59 дүгээр хуралдааны тэмдэглэл гаргасан.	
4.4. Шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийг тогтвортой хөгжүүлэн эрдэм шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлж, эрдэмтэн, судлаачдын бүтээлч үйл ажиллагааг дэмжих					
22	4.4.1. салбарын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	2017 - 2020		Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхийг бэхжүүлэх тогтолцоог бүрдүүлэх, эрдэмтэн солилцоог дэмжих, эрдэм шинжилгээний байгууллагын дэргэдэх гарааны компанийг бэхжүүлэх, салбарын ажиллагсдын нийгмийн хамгааллын асуудлыг дэмжих зорилгоор “Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2019 оны 62 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг БСШУС-ын сайдын 2019 оны А/826 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна. 2019-2020 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийн санхүүжилт батлагдаагүй боловч үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахаар боломжит бүх хувилбарыг ашиглан ажиллаж байна	100%
23	4.4.2. салбарын	2017 -		Шинжлэх ухаан, технологийн салбарт нийт 4,277 хүн ажиллаж байна. Нийт	70%

<p>үйл ажиллагааны цар хүрээтэй уялдуулан эрдэм шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлж чадваржуулах</p>	<p>2020</p>			<p>ажиллагсадын 75.8 хувь буюу 3,246 нь үндсэн орон тооны, 24.2 хувь нь гэрээт ажилтан байна. Үндсэн ажилтан, албан хаагчдын 44 хувь нь буюу 1,917 эрдэм шинжилгээний ажилтан байгаагийн дотор шинжлэх ухааны доктор (Sc.D) 109, боловсролын доктор (Ph.D) 724, магистрын зэрэгтэй эрдэм шинжилгээний ажилтан 1071 байгаа нь нийт эрдэм шинжилгээний ажилтны 58.6 хувийг бүрдүүлж байна. “Эрдэнэс 5 толгой” ХК-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд хэрэгжүүлж буй бакалавр, магистр, докторын сургалтын суралцагчдад олгох уралдаант шалгаруулалтыг онлайнаар зохион байгууллаа. Тус уралдаант шалгаруулалтад нийт 9 их сургуулийн доктор, магистерийн түвшинд суралцаж буй 31 нэр дэвшигч болон бакалаврын түвшний 7 баг материалаа ирүүлснээс 8 докторант тус бүр 6,000,000 төгрөг, 5 магистрант тус бүр 4,000,000 төгрөг, Бакалаврын оюутны баг 7 шалгарч тус бүр 5,000,000 төгрөг буюу нийт 108,000,000 төгрөгийн сургалт, судалгааны тэтгэлгийг олголоо. -Докторын зэрэг хамгаалсан 45 нас хүртэлх судлаачдын судалгааны ажлыг инноваци болгох, шинэ үеийн эрдэмтэн бэлтгэх зорилгоор “Докторын дараах судалгаанд сайдын нэрэмжит инновацийн тэтгэлэг олгох журам”-ын дагуу инновацийн тэтгэлэг олгох 10 бүтээлийг нээлттэй, уралдаант зарчмаар сонгон шалгаруулсан бөгөөд нийтдээ 100.0 сая төгрөгийн грантын 2020 онд санхүүжилт татагдсан шалтгаанаар олгоогүй байна. Шинжлэх ухаан, залуу ажилтныг орчин үеийн судалгааны арга зүй эзэмшүүлэх, чадавхжуулах зорилгоор “Эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүллээ хэвлүүлэх арга зүй” сургалтыг ШУТИС-тай хамтран цахимаар зохион байгуулж 200 гаруй залуу судлаач хамрагдсан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Springer Nature-ийн хамтын ажиллагааны хүрээнд БСШУСЯ, ШУТСан, ШУА болон төрийн өмчийн их сургууль, судалгааны хүрээлэнгүүдийн нийт эрдэм шинжилгээний ажилтан, багш, оюутнуудад зориулан Nature брэндийн бүх сэтгүүлийг үнэ төлбөргүйгээр унших боломжийг олгосон.</p>	
<p>24 4.4.3. эрдэмтэн, судлаачид өндөр хөгжилтэй орнуудад суралцах, мэргэжил дээшлүүлэх, ахисан түвшний судалгаа хийх,</p>	<p>2017 - 2020</p>			<p>Монголын сансрын судалгаа хөгжүүлэлтийн төв MAPCA-аас Монголын говьд сансрын тусгай аялал жуулчлалын төв, сансар судлалын чөлөөт бүс байгуулахаар зорьж MARS-V төслийн талаар онлайн хурлыг зохион байгууллаа. Хуралд сансар, Ангараг гарагийн судалгаа шинжилгээгээр дэлхий дахинаа алдаршсан нөлөө бүхий эрдэмтэд болон дэлхийгээс Ангараг гараг дээр хөл тавихаар сонгосон анхны сансрын нисэгчид оролцож цахимаар илтгэл тавилаа.</p>	<p>70%</p>

	гадаадын нэр хүндтэй эрдэмтдийг урьж ажиллуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх					
25	4.4.4. гадаадад ажиллаж байгаа нэр хүндтэй, чадварлаг эрдэмтэн, судлаачдыг эх орондоо ирж ажиллах нөхцөл боломжоор хангах, дотоодын судалгааны ажилд оролцоход нь дэмжлэг үзүүлэх	2017 - 2020			Хилийн чанадад нарийн мэргэжлийн, академик ажил эрхэлж байгаа монголчуудын виртуал платформ байгуулж монгол иргэдийн эдийн засаг нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэх зорилго бүхий зорилтот төслийг хэрэгжүүлэхээр 2021 оны салбарын төсөвт шаардагдах санхүүжилтийг тусгасан. Төслийн үр дүнд Хилийн чанадад нарийн мэргэжлийн, академик ажил эрхэлж байгаа монголчууд тэдэнтэй хамтран ажиллах Монголд буй мэргэжил нэгтгүүдийн хамтын ажиллагааны үр дүнд тухайн чиглэлд сурч ажиллах хүсэлтэй залуусыг дэмжих бодлогыг тодорхойлоход хувь нэмэр болно. Улмаар энэхүү бодлого болон бусад үйл ажиллагаа өргөжихийн хүрээнд сургалтын шинэ арга зам бий болох юм.	70%
26	4.4.5. эрдэм шинжилгээний ажилтны мэдлэг чадвар, бүтээлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг олон улсын үнэлгээний жишигт нийцүүлж, үр дүнд тохирсон цалин, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх	2017 - 2020			Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4,5 дугаар хавсралтын дагуу Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн болон ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг боловсруулж, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд болон Шинжлэх ухааны академийн саналыг тусган эцэслэн боловсруулсан. Журмын дагуу Боловсрол, шинжлэх ухаан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар батална. Ийнхүү батлагдсанаар эрдэм шинжилгээний ажилтнууд ур чадварын нэмэгдэл авах эрх зүйн зохицуулалт бүрдэх ба журамд заасны дагуу эрдэм шинжилгээний ажилтны ур чадварын болон мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэхээр зохицуулагдаж буй юм	90%

27	4.4.6. салбарын мэргэжилтнүүдийг мэдлэг, технологи дамжуулалт, технологийн менежмент, инновацийн удирдлагын чиглэлээр мэргэшүүлэх, мэргэшлийн зэрэг олгох тогтолцоо, механизмыг бий болгох	2017 - 2020		Шинжлэх ухааны паркийн захиргаа - ӨМӨЗО “Галт Бамбар” Өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх төвтэй мэргэжилтнүүдийг мэдлэг, технологи дамжуулалт, технологийн менежмент, инновацийн удирдлагын чиглэлээр, мэргэшүүлэх чиглэлээр санамж бичиг байгууллаа.	90%
28	4.4.7. эрдэм шинжилгээний байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг шинэчлэн мөрдүүлэх	2017 - 2020		Дэлхий дахинд үүсээд буй КОВИД-19 цар тахлын үеийн нөхцөл байдлын үед эрдэм шинжилгээний байгууллагын хэрхэн ажиллах тухай хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг нарийвчлан заасан зөвлөмжийг байгууллагуудад хүргүүлсэн. Байгууллага тухайн зөвлөмжид үндэслэн дотоод журмаа өөрчлөн мөрдүүлэн ажиллаж байна.	100%
29	4.4.8. шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд судалгаа боловсруулалтын ажлын болон судлаачийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх	2017 - 2020		БСШУ-ны сайдын 2007 оны 454 дүгээр тушаалаар батлагдсан “Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрэм”-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг боловсруулж судлаачдаас санал авч нэгтгэн дүрмийн төслийг боловсруулсан. ЮНЕСКО-ийн 2017 оны Ерөнхий бага хурлын чуулганаар батлагдсан “Шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний ажилтнуудад зориулсан зөвлөмж”-ийг монгол хэлнээ орчуулан, хянан тохиолдуулж ЮНЕСКО-ийн цахим хуудсанд байршуулсан. Энэхүү зөвлөмжид туссан судлаачийн ёс зүйтэй холбоотой асуудлыг тусган журмын төслийг сайжруулан боловсруулж байна. БШУ-ны сайдын 2020 оны 12 дугаар сарын 02-ны А/51 дүгээр тушаалаар дээрх зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг боловсруулж, бэлтгэх ажлыг зохион байгуулахыг Шинжлэх ухааны газарт	70%

				үүрэг болгосон. Энэхүү тайлан гарсны дараагаар дүрмийн төсөлд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусгаж эцэслэх боломжтой болно.	
4.5. Шинжлэх ухаан, технологийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга байгууламж, лабораторийн орчин, нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгох					
30	4.5.1. судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, дэвшилтэт технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны парк байгуулах	2017 - 2020		Монгол Улсад Шинжлэх ухааны парк байгуулах техник эдийн засгийн урьдчилсан судалгааг гаргасан. Судалгааны ажлууд дээр үндэслэн "Монгол Улсад Шинжлэх ухааны парк байгуулах техник, эдийн засгийн үндэслэл" боловсруулах ажлын /техникийн/ даалгаврыг боловсруулсан. БСШУС-ын сайд 2019 оны 12 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд БНХАУ-д айлчлал хийсэн айлчлалын хүрээнд зохион байгуулагдсан БСШУС-ын сайд, БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн сайд Ван Жи Ган нарын уулзалтаар Монгол Улсад Шинжлэх ухааны парк байгуулах нарийвчилсан төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулахад БНХАУ-тай хамтран ажиллах тохиролцоонд хүрсэн. Монгол Улсад Шинжлэх ухааны парк байгуулах ТЭЗҮ-д үндэслэн шаардагдах хөрөнгийг гадаадын зээл тусламжид хамруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын тогтоол гарсан. Урьдчилсан судалгаагаар Шинжлэх ухааны паркийг бүтээн байгуулах хамгийн тохиромжтой байршлын нэгээр Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг, Хөшигтийн хөндийд төлөвлөж байгаа "Шинэ Зуунмод" дагуул хот гэж тогтоогдсон бөгөөд энэ талаар холбогдох төрийн болон орон нутгийн байгууллагуудтай зөвшилцөж байна. Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж, хуулийн төсөлд санал авахаар 13 яамдад 2020 оны 11 сард албан тоот хүргүүлсэн.	50%
31	4.5.2. шинжлэх ухаан, технологийн кластер, хотхон байгуулж, татвар, санхүү, хөрөнгө оруулалтын таатай нөхцөлөөр дэмжих	2017 - 2020		Улсын төсвийн санхүүжилтээр "Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор"-ын газрын асуудлыг шийдвэрлүүлж, зураг төслийг боловсруулан бүтээн байгуулалтын ажлыг 2020 оны 10 дугаар сард эхлүүлсэн. Уг кластер нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнд 4,8 га талбайд баригдах ба 74,300 м2 ашиглалтын талбай бүхий үндсэн 7 хэсэг барилга, байгууламжаас бүрдэх бөгөөд цогцолборыг 2022 онд ашиглалтад оруулна. 2020 оны улсын төсөвт 3 тэрбум, 2021 оны улсын төсөвт 24 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд нийт хөрөнгө оруулалт нь 94.0 тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөн.	100%
32	4.5.3. эрдэм шинжилгээний	2017 -		2019-2020 онд 3,5 тэрбум төгрөгийн төсөвтэй Шинжлэх Ухааны Академийн өргөтгөлийн барилгыг Баянзүрх дүүрэгт Шинжлэх ухааны академийн	100%

байгууллагыг зориулалтын барилга байгууламжаар хангаж, ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах	2020		хүрээлэнгүүдийн нэгдсэн хотхонд баригдсан. Уг барилга нь Улаанбаатар хотын Ерөнхий архитектор бөгөөд нийслэлийн барилга хот, ерөнхий төлөвлөгөөний газрын даргын баталсан эскиз зургийн дагуу 15x19 м харьцах нийт 2280 м2, зоорийн давхартай 8 давхар, Их чуулганы болон Тэргүүлэгчдийн хурлын танхим бүхий конторын барилга угсралтын ажлыг “Хөх бүрдний Эх” ХХК гүйцэтгэн 2020 оны 11-р сард Улсын комисст хүлээлгэн өгсөн. Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн үйл ажиллагааг өргөтгөх зорилгоор одоогийн эмнэлгийн суурин дээр “Дорно дахины уламжлалт мэдлэг ухааны судалгаа, сургалтын олон улсын цогцолбор” -ыг барихаар төлөвлөж, уг барилгын загвар /эскиз/ зураг, архитектур төлөвлөлтийн болон барилгын ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг батлуулж Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөнд тусгасан. Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн шинэ барилгын зураг төслийг хийх ажлын санхүүжилтийг 2021 оны Барилга хот байгуулалтын сайдын төсвийн зураг төсөл боловсруулах зардлаас гаргах саналыг тус яамнаас хүргүүлээд байна. 2020 оны улсын төсөвт шинжлэх ухааны салбарын их засварын ажилд 127.5 сая төгрөг батлагдсан. Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спортын танхим бүхий цогцолборын барилгыг 2020 оны 9-р сард хүлээн авч ашиглалтад оруулсан. Улсын төсвийн санхүүжилтээр “Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор”-ын газрын асуудлыг шийдвэрлүүлж, зураг төслийг боловсруулан бүтээн байгуулалтын ажлыг 2020 оны 10 дугаар сард эхлүүлсэн. Уг кластер нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнд 4,8 га талбайд баригдах ба 74,300 м2 ашиглалтын талбай бүхий үндсэн 7 хэсэг барилга, байгууламжаас бүрдэх бөгөөд цогцолборыг 2022 онд ашиглалтад оруулна. 2020 оны улсын төсөвт 3 тэрбум, 2021 оны улсын төсөвт 24 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд нийт хөрөнгө оруулалт нь 94.0 тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөн.	
33 4.5.4. олон улсын стандартад нийцсэн лабораторийн тоног төхөөрөмжийг орчин үеийн судалгааны шаардлагад	2017 - 2020		Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Салбар дундын нээлттэй, сүлжээ лабораторийн итгэмжлэлийн техникийн шаардлага болон Судалгааны нээлттэй, дундын болон сүлжээ лабораторийн стандарт, эрх зүйн зөвлөх үйлчилгээ” сэдэвт /БСШУСЯ. АХБ-ны L2766-MON:/ зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд Монгол улсын шинжлэх ухааны байгууллага, их дээд сургууль, хувийн болон үндэсний хүрээлэн төвүүдийн дэргэд судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 310 лаборатори байна. Төслийн явцад лабораторийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг судлан жагсаалт гаргахын зэрэгцээ үндэсний ба олон улсын хэмжээнд итгэмжлэлд хамрагдсан лабораторийн судалгааг гаргав.	90%



	нийцүүлэн тогтмол шинэчилж, магадлан итгэмжлэгдсэн лабораториудыг байгуулах			2020 оны байдлаар улсын хэмжээнд 164 лаборатори итгэмжлэгдсэнээс их сургууль хүрээлэнгийн харьяа 13 лаборатори (7.9%), үндэсний болон олон улсын хэмжээнд итгэмжлэгдсэн бол тухайн салбарын нээлттэй, дундын лабораторийн сүлжээнд нэгдэх боломжтой яам, агентлаг, тусгай газрын 11 лаборатори итгэмжлэгдсэн байна. Монгол Улсын 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинжлэх ухааны байгууллагуудад 200 ширхэг суурин компьютер нийлүүлэх худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 405.9 сая төгрөгийн гэрээг “Ай ти зон” ХХК-тай байгуулсан. Сайдын тушаалаар хувариалтыг батлуулсан.	
34	4.5.5. салбар дундын судалгааны нэгдсэн, төрөлжсөн лаборатори, үндэсний хэмжээний төв, хүрээлэн байгуулах, чадавхжуулах замаар судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих	2017 - 2020		Салбар дундын нээлттэй, сүлжээ лабораторийн үйл ажиллагаа зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Дээд боловсролын шинэчлэлийн төсөл”-ийн хүрээнд “Лабораторийн судалгаа хөгжлийн зөвлөх” 18/09, “Лабораторийн магадлан итгэмжлэлийн зөвлөх” 18/10 зөвлөх үйлчилгээний судалгаа хийгдэж зөвлөмж гаргасан. Энэхүү ажлын хүрээнд өөр, өөр чиглэл үүрэг бүхий томоохон сургалт, судалгаа, шинжилгээ, хяналтын нийт 54 байгууллагын 310 лабораторийг хамруулсан. Төслийн явцад лабораторийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг судлан жагсаалт гаргахын зэрэгцээ үндэсний ба олон улсын хэмжээнд итгэмжлэлд хамрагдсан лабораторийн судалгааг гаргав. Төрийн өмчийн их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудад олон улсын стандартад нийцсэн үндэсний хэмжээний судалгааны жишиг лабораторийг улсын хөрөнгө оруулалт болон олон улсын хамтын ажиллагаа зээл тусламжийн хүрээнд байгуулж байна. Үүнд: АШУҮИС-ийн “Цөм лаборатори”, ШУТИС-ийн “Хүнс судлалын эрдэм шинжилгээний төв”, ХААИС-ийн “ХАА-н гаралтай бүтээгдэхүүний хяналт үнэлгээний төв лаборатори”, МУИС-ийн “Лазерийн судалгааны лаборатори” зэрэг орчин үеийн өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмж бүхий томоохон лабораториуд шинээр байгуулагдан ажиллаж байна. Нээлттэй лабораторийн журмын төслийг боловруулж байна. “Шинжлэх ухаан, технологийн тухай хууль”-ийн нэмэлт, өөрчлөлтөөр 8.1.19-д дээрх журмыг батлах эрх салбарын сайдад эрх олгогдохоор тусгасан тул хууль батлагдсаны дараа Захиргааны ерөнхий хуулийн дагуу боловсруулан батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлнэ.	100%
35	4.5.6. технологи дамжуулах төв, гарааны компани,	2017 - 2020		Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрт энэхүү зорилтууд туссан. Үе шаттайгаар хэрэгжүүлж байна.	50%

	инкубатор байгуулж, технологи бойжуулах, туршин нэвтрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх					
36	4.5.7. судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах технологийн бирж ажиллуулах	2017 - 2020			Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрт энэхүү зорилтууд туссан. Үе шаттайгаар хэрэгжүүлж байна.	30%
37	4.5.8. салбарын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, олон улсын шинжлэх ухааны мэдээллийн сүлжээний нэг хэсэг болгон нээлттэй ажиллуулах, эрдэм шинжилгээний номын сангуудын нэгдмэл үйл ажиллагааг хангаж, цахим сүлжээг нэвтрүүлэх	2017 - 2020			Азийн хөгжлийн банкны MON TA-9375 техникийн туслалцааны төслийн хүрээнд Нээлттэй шинжлэх ухааны платформыг хөгжүүлэх ажлыг Infoson ХХК гүйцэтгэж байна. Платформыг хөгжүүлэх ажлын явцыг талаар АХБ-ыг тогтмол мэдээллээр хангаж ажиллаж байгаа болно. КОВИД19 цар тахлын улмаас ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх хугацааг 2021 оны 1 дүгээр улирал болгож сунгасан. Платформын эхний хувилбарыг ажиллуулахад шаардлагатай 3 виртуал серверийг үүсгэсэн. Эхний ээлжинд эрдэм шинжилгээний хурлын удирдлага, онлайн хурал болон статистик мэдээг анхан шатны нэгжээс авах хэсгийг ашиглалтад оруулаад байна. Бүтээлийн хуулбарлалтыг илрүүлэх системийг хөгжүүлэх, зөвлөмж боловсруулах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зөвлөх үйлчилгээг Mongolian Digital Knowledge Solutions ХХК-аар гүйцэтгүүлж судалгааны тайланг хүлээж авлаа. Судалгаагаар бүтээлийн хуулбарлалтыг илрүүлэх олон улсын туршлага, үндэсний хэмжээнд хуулбарлалтыг илрүүлэх платформыг хөгжүүлэхэд тавигдах шаардлага, анхаарах асуудлуудын талаар зөвлөмж боловсруулсан болно. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн салбар, инновацийн үйл ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичиг, статистик тоо мэдээллийг салбарын бодлого боловсруулагчдад зориулсан GoSpin нэгдсэн платформд тогтмол оруулж байна. Зарим бодлогын баримт бичгийн англи хэлээрх албан бус орчуулгын хамт оруулж байна. БШУ-ны сайдын тушаалаар төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа,	90%

				шинжилгээний ажлын ШУТСанд хадгалагдаж буй тайлангуудыг олон нийтэд нээлттэй болголоо. КОВИД19 цар тахлын улмаас шинжлэх ухааны салбарын зардлыг тэвчиж болох зардалд оруулсантай холбоотойгоор энэ жилийн төлбөр болох 41,464 ам.доллар төлөгдөөгүй байна. Дээрх гэрээнүүд 2020 онд дуусгавар болж байгаа бөгөөд 2021 оноос шинэчлэхээр санал солилцож Springer Nature болон Research4Life хөтөлбөрийн шинэчилсэн лицензийн гэрээний төслийн саналаа ирүүлээд байна. их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай 2021 оноос лицензийн төлбөрийн хагасыг БШУ-ны яам, хагасыг нь байгууллагууд өөрсдөө төлөхөөр тохиролцоонд хүрсэн	
38	4.5.9. салбарын дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг татварын бодлогоор дэмжих асуудлыг судлан шийдвэрлэх	2017 - 2020		Инновацийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу технологи дамжуулах төв, эсхүл хамтын оффисд гишүүнчлэлээр бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг төрөөс татварын бодлогоор дэмжих журмын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.	50%
4.6. Шинжлэх ухаан, технологийн салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх					
39	4.6.1. шинжлэх ухаан, технологийн салбарын гадаад хамтын ажиллагааны чиглэл, стратегийн түнш байгууллагыг тодорхойлж, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	2017 - 2020		Беларусь, Вьетнам, Тайван, БНХАУ-ын Байгуулийн ШУ сан, Евразийн шинжлэх ухааны холбоотой санамж бичиг байгуулан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна. ОХУ-ын Суурь судалгааны сан, БНХАУ-ын Шинжлэх ухаан технологийн яамтай хамтран ажиллах санамж бичиг байгуулан хамтарсан судалгааны төслийн хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байна. Монгол Улсын ХХАХҮЯ болон БНСУ-ын Засгийн газрын харьяа Хөдөөгийн хөгжлийн удирдах газартай байгуулсан санамж бичгийн хүрээнд КОПИА Монгол төвийг байгуулан солонгосын буцалтгүй тусламжийн сангаас хөдөө аж ахуйн чиглэлийн төслүүдийг хэрэгжүүлж байна. Япон Улсын Шинжлэх ухаан, технологийн агентлаг (JST, Japan Science and Technology Agency)-аас хэрэгжүүлдэг CATREPS (SATREPS, Science and Technology Research Partnership for Sustainable Development) хөтөлбөрт МУИС-ийн профессор Ж.Батхүү, Токиогийн их сургуулийн профессор Т.Асами нарын хамтран дэвшүүлсэн “Нүүдэлчин Монголчуудын уламжлалт мэдлэгт тулгуурлан	100%

				бэлчээрийн тэжээлийн зэрлэг ургамлыг зүй зохистой ашиглах нь” төсөл хэрэгжиж байна. Япон улсын Шинжлэх ухаан, технологийн агентлагаас 1 жилд гаргах санхүүжилтийн дээд хэмжээ нь 35 сая иен, ЖАЙКА байгууллагаас 1 жилд гаргах санхүүжилтийн дээд хэмжээ нь 60 сая иен (ойролцоогоор 1.4 тэрбум төгрөг) юм. Монгол судлалыг чиглэлээр суралцаж буй гадаадын шилдэг монгол судлаачдыг Монгол Улсын их, дээд сургуултудын магистр, докторын хөтөлбөрт тэтгэлгээр сургах ажлын хүрээнд 2019-2020 оны хичээлийн жилд Ц.Дамдинсүрэнгийн нэрэмжит тэтгэлэгт: Миягашева Суржана Борисовна Орос улсын ШУА-ийн Сибирь дэх салбарын Монгол, Төвөд, Буддын судлалын эрдэм шинжилгээний ажилтан, Ш.Лувсанванданын нэрэмжит тэтгэлэгт Үзэсгэлэн Япон улсын Шига Мужын Их Сургуулийн судлаач, Б.Ренчинийн нэрэмжит тэтгэлэгт ХБНГУ-ын Брннын их сургуулийн судлаач гар тус тус шалгарсан.	
40	4.6.2. дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, судлаачдын хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгааны үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, дэвшилтэт технологийг нутагшуулахад чиглэсэн санаачилга, хөрөнгө оруулалт, бүтээлч үйл ажиллагааг дэмжих	2017 - 2020	Монгол Улсын БШУЯ, БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн яам хооронд байгуулсан хамтарсан судалгааны хөтөлбөрийн хүрээнд 2020 оноос хэрэгжүүлэх 6 хамтарсан төслийн сонгон шалгаруулалтыг эцэслэж БШУ-ы сайдын А/86 дугаар тушаалаар батлуулав. 2021 оноос эхлэн хэрэгжих төслийн саналуудыг 2020 оны 10-р сараас хүлээн авч сонгон шалгаруулалтыг эхлүүллээ. Оросын Холбооны Улсын Оросын суурь судалгааны сантай 2020 оноос эхлэн хэрэгжүүлэх 22 судалгааны төслийг БШУ-ын сайдын 2020 оны А/86 дугаар тушаалаар батлуулав. Евразийн шинжлэх ухааны судалгааг дэмжих холбоотой байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд 2020 оноос эхлэн хэрэгжүүлэх олон талт хамтарсан судалгааны төслийг БСШУС-ын сайдын 2018 оны А/192 дугаар тушаалаар батлуулав. Бүгд Найрамдах Вьетнам Улсын Шинжлэх ухаан, технологийн яамтай хамтран 2020 оноос эхлэн хэрэгжүүлэх хамтарсан төслийн саналыг хүлээн авч, 1 төслийг сонгон шалгаруулж батлуулсан. Беларусийн суурь судалгааны сантай хамтарсан 2020 оноос хэрэгжүүлэх 3 төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байна.	100%	

41	4.6.3. гадаадын нэр хүндтэй эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтарсан судалгааны төв, лаборатор байгуулахыг дэмжих	2017 - 2020		“Монгол Улсад инкубаторын үйл ажиллагааг хэрэгжүүлэх мэдээллийн серверийн бүтээн байгуулалт” болон “Технологи дамжуулах төвийн платформыг байгуулах” төслүүдийг БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн яамтай хамтран хэрэгжүүлж байна. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлсэн Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд АШУҮИС-ийн “Цөм лаборатори”, ШУТИС-ийн “Хүнс судлалын эрдэм шинжилгээний төв”, ХААИС-ийн “ХАА-н гаралтай бүтээгдэхүүний хяналт үнэлгээний төв лаборатори”, МУИС-ийн “Лазерийн судалгааны лаборатори” зэрэг орчин үеийн өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмж бүхий томоохон лабораториуд шинээр байгуулагдан ажиллаж байна. Хими, хими технологийн хүрээлэн БНХАУ-н Уул уурхай металлургийн хүрээлэнтэй хамтарсан “Уул уурхайн үйлдвэрлэл, судалгааны лаборатори”-ийг байгуулан ажиллаж байна.	100%
42	4.6.4. судалгааны лабораторийн бааз, инновацийн дэд бүтцийг бэхжүүлэх болон шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлээр нарийн мэргэшсэн судлаач бэлтгэхэд гадаадын зээл, тусламжийн тодорхой хэсгийг зарцуулах	2017 - 2020		БНУУ-ын Засгийн газрын тэтгэлгээр жил бүр 20 доктор, БНХАУ, ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр докторын сургалт болон аспирантурт оюутнууд суралцаж байна. Мөн Боловсролын зээлийн сангаас өндөр хөгжилтэй оронд докторын сургалтад хамрагдах оюутнуудын сургалтын төлбөрийг санхүүжүүлж байна.	100%
43	4.6.5. гадаад орнуудтай судлаач солилцох хөтөлбөр хэрэгжүүлэх	2017 - 2020		БСШУСЯ, БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн яамтай хамтран ажиллах хэлэлцээрийн хүрээнд залуу эрдэмтэн, судлаач, багш нарыг Хятадын “Авьяслаг залуу судлаачдын хөтөлбөр”-т хамруулан богино, дунд хугацаагаар ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Жил бүр залуу монгол судлаачдын зуны сургалтыг зохион байгуулж байна. 20 гаруй орны монгол судлаач, залуу эрдэмтэн, судлаачид энэ сургалтад хамрагдаж байна.	100%